Сургууль................................   Анги .......   Сурагчийн нэр..............................................

**Монгол хэл-3-р анги**

Гал сөнөөгчид өгсөн урам

Индонезийн нэгэн том дэлгүүрт гал гарчээ. Хэсэг хугацааны дараа гал командын машин ирж гал унтраах ажлаа эхлэхэд хүмүүс шаван ирж хэрхэн унтраахыг сонирхон харж зогсжээ. Харин дэлгүүрээс бүгд гарсан гэж бодож байтал хамгийн дээд давхарт нэгэн охин уйлж байх нь харагдав. Нэгэн гал сөнөөгч шат маш хурдан авчран дээш авирах үед цонхонд гал авалцаад охиныг харах боломжгүй болжээ. Энэ үед түүнийг харж зогссон нэг гал сөнөөгч " түүнд урам өгөн дэмжицгээе! гэхэд тэнд байсан хүмүүс гал сөнөөгчийг урамшуулан хашхирав. Галаас эмээж байсан гал сөнөөгч хүмүүсийн дэмжсэн дуунд зоригжиж охиныг аварч гаргажээ. Хэцүү байдалд орох үед нь түүнийг хүмүүс урамшуулснаар тэр хүч зориг орж, охиныг аварч чадсан юм.

**1.Зөв хариултыг сонгоорой.** **/6оноо/**

- Гал сөнөөгчийн хийсэн үйлдлийн учир шалтгаан юу байсан бэ?
  a) Хүмүүс түүнд итгэсэн
  b) Хүмүүс түүнийг урамшуулсан
  c) Хүмүүсийн урамд хүч зориг орж охиныг аварсан
- Мэргэжил нэгт гал сөнөөгчийн хэлсэн үгийг олоорой
  a) Охиныг аварцгаая
  b) Түүнд урам өгөн дэмжицгээе.
  c) Түүнд хүч зориг хайрлаарай.
- "дэмж**и**цгээе" үгийн балархай эгшиг ямар үүргээр орсон бэ?
  a) Зөөлрүүлэх
  b) Эгшигжүүлэх
  c) Ялгах
- Эхэд гарч буй улсын нэрийг олоорой.
  a) Монгол
  b) индонези
  c) Индонез
- Хэн? юу?яав? гэсэн асуултад хариулагдах өгүүлбэрийг олоорой.
  a) Гал сөнөөгч охиныг аврав.
  b)Хүмүүс урам хайрлав.
  c) Гал сөнөөгч шатаар авирав.
- "Урам " гэдэгтэй ойролцоо үгийг олоорой.
  a) Дэмжлэг
  b) Зориг
  c) Хүч

**2**. А хэсэгт тодруулсан үгийн **ойролцоо** утгатай үг, Б хэсэгт тодруулсан үгийн **эсрэг** утгатай үгийг нөхөж бичээрэй. **/2оноо /**

А. Зуны улиралд цаг агаар .................................. **дулаан** байдаг.
Б. **Хол** явъя гэвэл ............ -оос эхэл.

**3. Алдаагүй бичсэн өгүүлбэрийг олоорой.** **/1оноо/**

А. Миний дүү дэрэм цэцэрлэгт оров .   Б. Эмээ Говь-Алтай аймгаас ирлээ.

4. “Сонирх**о**н, зогсс**о**н” үгсийн тодруулсан балархай эгшгийн үүргийг тайлбарлан бичээрэй. **/2оноо/**

.........................................................................................................................................................
.........................................................................................................................................................

5.Өөрийн мэддэг оноосон нэр ангилал тус бүрт 2-ыг бичээрэй. **/3 оноо/**

Улс орон :..........................................................................................................................

Аймаг сум:.........................................................................................................................

Гол мөрөн:.........................................................................................................................

6.Асуултанд тохируулан дэлгэрүүлж бичээрэй. **/2оноо/**




7. Дараах оньсогуудыг таагаад, эсрэг ба ойролцоо утгатай үгийг ялган бичээрэй.**/2оноо /**

Мэддэгт мэргэн цоохор
Мэддэггүйд эрээн цоохор /…………………………../

Төрсөн бие тэнгэрт
Тулсан таяг газарт /……………………./

Эсрэг утгатай үг:..................................................................................................................

Ойролцоо утгатай үг: ........................................................................................................

**Нийт- 18 оноо**

Сургууль................................    Анги .......    Сурагчийн нэр..............................................

**3-р анги математик**

**1. Тоо тус бүрийг тоймлон бичээрэй.** **/2оноо /**

а. 5381, 2516-ыг аравтаар тоймлоорой: ______________________

б. 5381, 2516-ыг зуутаар тоймлоорой: ______________________

**2. Тоон шулуун ашиглан даалгаврыг гүйцэтгээрэй** **/2 оноо /**




а. 1-ээр нэмэгдүүлж тоонуудыг бич.    б. 1-ээр хорогдуулж тоонуудыг бич.

–6, ____, ____, ____, ____, ____.    –2, ____, ____, ____, ____, ____.

**3. Квадратын нэг тал нь 162 см бол хүрээний уртыг олоорой.** **/1 оноо /**

А. 648см    б. 324см    в. 486см    г. 500 см

**4. 8600м = ................км ...........м** **/1 оноо /**

А.80км 600м    В. 8км 600м    С. 8км 60м    D. 8км 600м

**5. Өгсөн өнцөг бүр ямар өнцөг болохыг таньж, доорх зайд бичээрэй.** **/2оноо/**




**6. Тоон илэрхийллийг бодоод зөв хариуг олоорой.** ***/ 2оноо/***

***600-359 + (4001-3996) x 9 =***

**7. Ээж 3, эгч 2 дээл урлав. Дээл тус бүрт 4м торго орсон.** ***/2оноо/***

а. Нийт хэдэн метр торго орсон бэ?

б. Эгчийн дээл хийсэн торго нь ээжийнхээс хэдэн метрээр богино вэ?

а. б.

8.Өгсөн цэгүүдийг холбож, хэрчим зураарай. Хэрчим бүрийн хэмжээг шугамаар хэмжээд, хэмжээг хүснэгтэд бичээрэй. ***/4 оноо/***




| хэрчим | урт |
|---|---|
| АБ | .......... см ............мм |
| БВ | .......... см ............мм |
| ВГ | .......... см ............мм |
| АГ | .......... см ............мм |

9. Хүүхдүүдийн бүжгийн тэмцээний оноог доорх графикаар харуулав. / 2оноо /

**Асуултад хариулаарай.**

А. Баяр хэдэн оноо авсан бэ ?
а. 10 б. 13 в. 14 г. 15

Б. Хэн хамгийн их оноо авсан бэ ?
а. Даш б. Оргил в. Баяр г. Сүрэн

В. Даш Сүрэнгээс хэдээр их оноо авсан бэ?
..............................................................

Г. Хүүхдүүд нийт хэдэн оноо авсан бэ?
.....................................................................




**Нийт- 18 оноо**